

## "ӨВ СОЁЛ - ЦАГААН САР" УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

2023.02.16

Дархан-Уул аймаг

Монгол үндэсний өв соёлыг хадгалж уламжлан өвлүүлэх зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын мастер тогооч Ч.Зунгарайгийн санаачилгаар аймгийн Ахмадын хөгжлийн төв, Соёл, урлагийн газар хамтран **"Өв соёл-Цагаан сар"** уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлгийг аймгийн Ахмадын хөгжлийн дарга А.Янжмаа, Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ нар нээж хөтөлгөөр аймгийн Музейн дарга Д.Жанбалдорж ажиллалаа.



Тус сургалт, хэлэлцүүлгээр:

1. "Цагаан сарын түүх ёс заншил" -ын талаар аймгийн Музейн дарга, Дархан нутаг судлаач Д.Жамбалдорж,
2. "Ууц, өвчүү тавих, хөндөх ёсон" - Монгол Улсын мастер тогооч Ч.Зунгарай
3. "Идээ таваг засах ёсон" сэдвээр - Дархан сумын 6 дугаар багийн ахмад настан Л.Долгор
4. "Мөр гаргах ёсон" - Хараагийн Дарь Эх ламын Гэцогдаржайлин хийдийн хамба лам Ж.Мөнхсүх
5. "Золгох, хадаг барих ёсон" Монгол Улсын өв соёл, цоллоочдын холбооны тэргүүн, Улсын морь, бөх цоллооч, Ерөөлч магтаалч МУСТА Б.Дарханням
6. "Цагаан сар ба уламжлалт наадгай" - Хөнгөн атлетикийн спортын мастер, Ази тивийн мөнгө, хүрэл медальт, Өргөө багийн ахмад настан Л.Содном нар мэдээлэл хийлээ.



Хэлэлцүүлгийн үеэр ахмадууд болон ажилтан албан хаагчид нийт 46 иргэн

хамрагдаж илтгэл тавигчдаас нээлттэй хэлэлцүүлгийг идэвхитэй оролцож уг сургалтыг жил бүр уламжлан зохион байгуулахаар боллоо.



Мөн сургалт, хэлэлцүүлгийн үеийн агуулгыг видео бичлэг хийн хадгалж архивлалаа. Сургалтын мэдээг орон нутгийн хэвлэл мэдээллийн Мэдээлэл технологийн алба, DBS, RGB телевиз, Ахмадын хөгжлийн төв, Соёл, урлагийн газрын цахим сайтуудаар олон нийтэд мэдээлж ажиллалаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛ, УРЛАГИЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ЧИНБИЛЭГ